МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 23 өдөр Дугаар А/607 Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээ
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 38 дугаар зүйлийн 38.1, 38.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Мөрөн бетон” ХХК, “Шаншиндэва” ХХК –ийн хүсэлтийг тус тус үндэслэн аймгийн Засаг даргын 2017 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн А/578 дугаар захирамжийн хавсралтын 6 дахь хэсэгт “Мөрөн бетон” ХХК (6156932)-д эзэмшүүлсэн Мөрөн сумын 8 дугаар баг “Нийгмийн даатгал”-ын баруун талд байршилтай 6712011923 нэгж талбарын дугаар бүхий зочид буудлын үйлчилгээний зориулалттай 595м^2 газрыг “Шаншиндэва” ХХК (6660975)-д үлдсэн 2 жилийн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн А/578 дугаар захирамжийн хавсралтын 6 дахь хэсгийг хүчингүй болгосугай.

3.Захирамжаар газар эзэмшигч хуулийн этгээд “Шаншиндэва” ХХК (6660975)-тай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Мөнгөнзул) нарт тус тус зөвшөөрсүгэй.

4.Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

5.Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.
6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

Захирамж-2023

6712011992